



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР**

**ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГААС СУДАЛГААНЫ ТАЛААР
БАРИМТЛАХ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх
Сургалт, судалгааны хүрээлэнгийн Судалгааны
албаны дарга, ахлах прокурор Б.Мөнхдорж

2023 он



Агуулга



1. Эрх зүйн үндэслэл, хэрэгцээ, шаардлага



2. Түүхэн уламжлал



3. Өнөөгийн нөхцөл байдал



4. Хүний нөөцийн мэргэшсэн байдал



5. Үзэл баримтлалын агуулга



6. Үзэл баримтлалыг хэрэгжүүлэх төлөвлөгөө



Эрх зүйн үндэслэл, хэрэгцээ шаардлага



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 05 сарын 13 өдөр

Дугаар 52

Төрийн ордон, Улаанбаатар хот

"АЛСЫН ХАРАА-2050" МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

- "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого"-ыг 1 дүгээр хавсралтаар, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа"-г 2 дугаар хавсралтаар, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин"-г 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
- "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг үндэслэн дараагийн үе шатны хүрэх үр дүнтэй нийцүүлэн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг боловсруулж, Монгол Улсын Их Хурлаар батлуулахыг Монгол Улсын Засгийн газар (УХуралсүх)-т үүрэг болгосугай.
- Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (УХуралсүх)-т үүрэг болгосугай:
 1. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үндэсний, салбарын, салбар хоорондын болон бүс нутаг, аймаг, нийслэлийн түвшний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгаж, шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсвийн болон санхүүжилтийн бусад эх үүсвэрээс төлөвлөн үе шаттайгаар хэрэгжүүлэх;
 2. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх ахлыг удирдан зохион байгуулах байнгын бүтэц, тогтолцоог бий болгох;
 3. Монгол Улсын Их Хурал болон Монгол Улсын Засгийн газраас баталсан дүнд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийг "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэх арга хэмжээг авах;
 4. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийн явцад 5 жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Монгол Улсын Их Хуралд танилцуулах.
- Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо /С.Бямбацогт/-нд даалгасугай.
- "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-ын үр дүнг илэрхийлэх үзүүлэлтүүд, Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилтууд нь агуулгаараа "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад тусгагдсан тул "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 19 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.
- Энэ тогтоолыг 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн дагах мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ТУШААЛ

2022 оны 12 сарын 27 өдөр

Дугаар А/137

Улаанбаатар хот

"Прокурорын байгууллагын 2023-2026 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө" батлах тухай

Монгол Улсын Прокурорын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийн 48.1.1, 48.1.8 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- Төрийн албаны тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл зэрэг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд нийцүүлэн боловсруулсан "Прокурорын байгууллагын 2023-2026 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө"-г хавсралтаар баталсугай.
- "Прокурорын байгууллагын 2023-2026 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Улсын ерөнхий прокурорын газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга нар болон Аймаг, нийслэл, тээвэр, дүүргийн прокурорын газрын ерөнхий прокуроруудад тус тус үүрэг болгосугай.
- "Прокурорын байгууллагын 2023-2026 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө"-г Улсын ерөнхий прокурорын газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд болон харьяа прокурорын газруудад хүргүүлэхийг Бодлого төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Булганцэцэг)-т даалгасугай.
- Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын ерөнхий прокурорын орлогч (М.Чинбат)-д үүрэг болгосугай.

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР,
ТӨРИЙН ХУУЛЬ ЦАХЗЫН
ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ



Б.ЖАРГАЛСАЙХАН

1531010933



Эрх зүйн үндэслэл, хэрэгцээ шаардлага

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг

- “Шинжлэх ухааны ололтод суурилсан судалгаа, шинжилгээний төвийг өргөжүүлж, шинжилгээ хийх нөхцөлийг сайжруулан, хууль хяналтын байгууллагуудын харилцан ойлголцол, хамтын ажиллагааг хөгжүүлнэ.”
- “Хууль сахиулах салбарын хууль, эрх зүйн орчныг сайжруулан, бүтээн байгуулалтыг дэмжиж, ажиллах нөхцөлийг дээшлүүлж, мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бэлтгэн өрсөлдөх чадварыг хөгжүүлнэ.”

“Прокурорын байгууллагын 2023-2026 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”

- “Судалгааны ажлын чанар, үр нөлөөг нэмэгдүүлэх, эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилт, түүнийг боловсронгуй болгох чиглэлээр судалгаа хийх”
- “Прокурорын мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх, прокурорын байгууллагын зардлаар магистр, докторын сургалтад хамруулах, прокурор, ажилтан бүр жилд нэгээс доошгүй сургалтад хамрагдсан байх”



Эрх зүйн үндэслэл, хэрэгцээ шаардлага

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг

- “Салбарын үйл ажиллагаанд шинжлэх ухааны өндөр түвшний технологийг нэвтрүүлэх бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, судалгаа, шинжилгээний баазыг бэхжүүлсэн байна.”

“Прокурорын байгууллагын 2023-2026 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”

- Прокурорын байгууллагаас хийх судалгааны үндсэн болон тэргүүлэх чиглэлийг тодорхойлох.
- Прокурор, ажилтнуудын судалгааны арга зүйн мэдлэг, чадварыг сайжруулах.
- Судалгааны ажлын чанар, үр нөлөөг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн нэгдсэн бодлого бий болгох



Түүхэн уламжлал

Гэмт хэргийн шалтгаан нөхцөл
судлах хүрээлэн

- БНМАУ-д гарч байсан гэмт явдлын шалтгаан нөхцөлийг судлах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ боловсруулах асуудлыг шийдвэрлэх зорилгын үндсэн дээр гэмт хэрэгтэй тэмцэх онол, арга зүйн үндсэн асуудал;
- Тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөл судлах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ боловсруулах;
- Хуулийн байгууллагуудаас зохиож буй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг судлан боловсронгуй болгох гэсэн 3 үндсэн сэдвийн хүрээнд 12-15 дэд сэдвээр судалгааг явуулсан байдаг.



Өнөөгийн нөхцөл байдал

Улсын Ерөнхий прокурорын газрын сургалт, судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй нэгж нь 2017-2022 онд нийт 29 судалгааг дангаар болон бусад байгууллага, зохион байгуулалтын бүтцийн нэгжийн прокуроруудын оролцоотой хийж гүйцэтгэснээс 5 суурь судалгаа, 24 хавсарга судалгаа байна.

2017-
2018

“Монгол Улсын хүн амын дундах амиа хорлох тохиолдол”, “Арван найман насанд хүрээгүй хүнийг хүчиндэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, шийдвэрлэлт” сэдвээр;

2019

“Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эм бэлдмэл, бодист донтсон буюу хамааралтай болсон иргэн албадан болон сайн дурын эмчилгээнд хамрагдсан байдал”, “Нийтэд тустай ажил хийлгэх ялын талаар олон улсын эрүүгийн эрх зүйн зохицуулалт, үр нөлөө”, “Гэмт хэргийн өсөлт, бууралтын шалтгаан, нөхцөл” сэдвээр;

2020

“Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн гаралт, шийдвэрлэлт, түүнд нөлөөлсөн шалтгаан нөхцөл” сэдвээр;

2021

Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид заасан хүүхдийн эрхийг зөрчих зөрчлийн гаралт, шийдвэрлэлт, шалтгаан нөхцөл”, “Хуулийн этгээдэд хариуцлага ногдуулж буй байдал” сэдвээр;

2022

“Цэргийн анги байгууллагад үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөл”, “Гадаад орны прокурорын байгууллагын бүтэц, чиг үүрэг”, “Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хүүхэд хохирсон гэмт хэргийн гаралт, шийдвэрлэлт, шалтгаан нөхцөл”, “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль зөрчих зөрчлийн гаралт, шийдвэрлэлт, шалтгаан нөхцөл” сэдвээр;

2023

“Прокурорын шийдвэр боловсруулах арга зүй”, “Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагааг сайжруулах арга зам”, “Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн гаралт, шийдвэрлэлт, шалтгаан нөхцөл” гэх мэт суурь болон хавсарга судалгааг хийсэн байна.



Өнөөгийн нөхцөл байдал







Хүний нөөцийн мэргэшсэн байдал

- Прокурорын байгууллагад ажиллаж буй прокуроруудын 6 буюу 0.9 хувь нь доктор, 203 буюу 32.5 хувь нь магистрын зэрэгтэй бол 15 буюу 2.4 хувь нь докторантурт суралцаж байна.
- Прокурорын туслах ажилтнуудын 11.6 хувь нь магистрын зэрэг хамгаалсан байна

ПРОКУРОР



ПРОКУРОРЫН ТУСЛАХ
АЖИЛТАН





Тулгамдаж буй асуудал

➤ Прокурорын байгууллагын хэмжээнд мэргэшсэн, гадаад хэлний мэдлэгтэй судлаач цөөн, судалгааны санхүүжилт улсын төсөвт тусгагддаггүй байсан зэрэг нь эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилт, тэдгээрийг боловсронгуй болгох чиглэлээр онол, арга зүйн болон бодлогын судалгааг бие даан хийх, олон улсын эрх зүйн хөгжлийн чиг хандлагыг судлахад хүндрэлтэй байжээ.



Тулгамдаж буй асуудал

- Улсын ерөнхий прокурорын газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, харьяа прокурорын газруудаас санаачлан судалгааны ажлуудыг хийж, гүйцэтгэж ирсэн нь сайшаалтай боловч судалгааны арга зүйн хувьд нэгдмэл бус;
- Прокурорын байгууллагын судалгааны ажлын чанар, үр нөлөөг нэмэгдүүлэх, үр дүнг практикт нэвтрүүлэх, хууль зүйн салбарын хөгжилд бодитой дэмжлэг үзүүлэхэд мэргэшсэн судлаачдыг бэлтгэх;



- Судалгааны ажил хийх эрх зүйн орчин, нөхцөлийг сайжруулах;
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд суурь судалгааны ажлын эзлэх хувийн жин харьцангуй бага байгаа тул магистрант, докторант нарыг эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцуулах;
- Прокурор, ажилтнуудын боловсролын зэргийг ахиулах, эрдэм шинжилгээний бүтээл туурвихад дэмжлэг үзүүлэх, зочин судлаачаар ажиллах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх зэрэг болно.



Үзэл баримтлалын агуулга

НЭГ. ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА

ХОЁР. ЭРХЭМ ЗОРИЛГО, ЗАРЧИМ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

ГУРАВ. СУДАЛГААНЫ ЧИГЛЭЛ, ТӨРӨЛ, САНХҮҮЖИЛТ

ДӨРӨВ. СУДАЛГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ, СУДЛААЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

**ТАВ. ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГААС СУДАЛГААНЫ ТАЛААР БАРИМТЛАХ ҮЗЭЛ
БАРИМТЛАЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**



Үзэл баримтлалын агуулга

НЭГ. ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА

Үзэл баримтлалын үндэслэл, шаардлага, прокурорын байгууллагын судалгааны талаарх түүхэн уламжлал, өнөөгийн нөхцөл байдал, хүний нөөцийн мэргэшсэн байдал зэргийг тусгасан.



Үзэл баримтлалын агуулга

ХОЁР. ЭРХЭМ ЗОРИЛГО, ЗАРЧИМ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Эрхэм зорилго

Прокурорын байгууллагын судалгааны ажилд шинжлэх ухаан, технологи, инновацийн дэвшлийг нэвтрүүлж, чанар, үр нөлөөг нэмэгдүүлэхэд оршино.



Үзэл баримтлалын агуулга

Судалгааны талаар баримтлах зарчим

Прокурорын байгууллагын чиг үүрэг, бодлого, зорилтын хүрээнд эрдэм шинжилгээний нийтлэг үнэт зүйлийг эрхэмлэн үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална.

- ✓ Прокурорын байгууллагын чиг үүрэг, бодлого, зорилтод нийцсэн байх;
- ✓ Шинжлэх ухааны арга зүйд тулгуурласан байх;
- ✓ Төр, хүн, хуулийн этгээдийн нууцлалыг хадгалах;
- ✓ Судлаачийн академик эрхийг хүндэтгэх.



Үзэл баримтлалын агуулга

Зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ





Үзэл баримтлалын агуулга

ГУРАВ. СУДАЛГААНЫ ЧИГЛЭЛ, ТӨРӨЛ, САНХҮҮЖИЛТ

Судалгааны үндсэн чиглэл

- Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилт;
- Зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилт;
- Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөл.

Судалгааны тэргүүлэх чиглэл

- Хүний эрх, эрх чөлөө;
- Төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах;
- Прокурорын байгууллагын бодлого, стратеги, менежментийн асуудал;
- Бусад.



Үзэл баримтлалын агуулга

УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэн нь энэхүү үзэл баримтлалыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах бөгөөд нэгж прокурорын газрууд нь дэмжлэг үзүүлж ажиллана.

Үзэл баримтлалын агуулга

Судалгааны төрөл

- ❖ Суурь судалгаа;
- ❖ Хавсарга судалгаа;
- ❖ Бодлогын судалгаа;
- ❖ Харьцуулсан судалгаа.





Үзэл баримтлалын агуулга

ДӨРӨВ. СУДАЛГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ, СУДЛААЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- Судалгааг прокурорын байгууллагын стратеги зорилт, үндсэн чиг үүрэгтэй нийцүүлэн **жил бүр төлөвлөж** хэрэгжүүлэх бөгөөд хэрэгжилт, судалгааны ажлын чанар, үр нөлөөнд тухайн жилийн эцэст дүгнэлт хийнэ.
- Судалгааны үр дүнд үндэслэн санал, зөвлөмж, гарын авлага боловсруулах, эрдэм шинжилгээний бүтээл эрхлэн гаргах, сургалт зохион байгуулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- Судлаач нь тухайн сэдвээр мэргэшсэн, бүтээлч, бусдад нөлөөлөх чадвартай, судалгааны арга зүйн мэдлэг, чадвартай байхаас гадна боловсролын түвшин, ажил хэргийн нэр хүнд, дадлага туршлага, судалгааны зорилтыг хэрэгжүүлэх чадвар зэргийг харгалзахаар тусгасан.



ТАВ. ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГААС СУДАЛГААНЫ ТАЛААР БАРИМТЛАХ ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин
Зорилт 1.				
Судалгааны ажил хийх эрх зүйн орчин, нөхцөлийг сайжруулах				
1	Судалгааны ажил хийх аргачлалыг боловсруулж, хэрэгжүүлэх.	2023 он	Аргачлал батлагдаж, хэрэгжсэн эсэх.	Судалгааны ажил хийх арга зүй сайжирч, судлаач прокурор ажилтны ур чадвар дээшилсэн байна.
2	Судалгааны үндсэн болон тэргүүлэх чиглэлээр хийх ажлын сэдвийг тодорхойлж, дангаар болон бусад байгууллагуудтай хамтран судлах.	2023-2027 он	Судалгааны ажлын сэдэв тодорхойлогдож, судалгааны байгууллагуудад хүргэгдсэн эсэх.	Дангаар болон бусад байгууллагуудтай хамтран зохих судалгаанууд хийгдсэн байна.
3	Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын дэд бүтэц, орчин нөхцөлийг сайжруулах.	2023-2027 он	Судалгааны ажил хийх нөхцөл бүрдсэн эсэх.	Судалгаа хийх орчин, нөхцөл хангагдсан байна.
Зорилт 2.				
Судалгааны бүтээлийн хууль зүйн шинжлэх ухааны салбарт эзлэх байр суурийг бэхжүүлэх				
1	Докторантур, магистрантурт суралцаж буй прокурор, ажилтнуудыг судалгааны ажилд оролцуулж, эрдэм шинжилгээний ажилд нь арга зүйн дэмжлэг үзүүлэх.	2023-2027 он	Докторантур, магистрантурт суралцаж буй прокурор, ажилтны судалгааг жил бүр шинэчлэн гаргаж, судалгааны ажилд оролцуулсан эсэх.	Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд нь арга зүйн дэмжлэг үзүүлж, зохих судалгаанууд хийгдсэн байна.
2	Прокурор, ажилтнуудаас хийсэн судалгаа, эрдэм шинжилгээний бүтээлийн оюуны өмчийг хамгаалах.	2023-2027 он	Оюуны өмчийг хамгаалах чиглэлээр зохих арга хэмжээ авсан эсэх.	Оюуны өмчийн гэрчилгээ авах зэргээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.
3	Импакт фактор бүхий олон улсын мэргэжлийн сэтгүүлд прокурор, ажилтнуудаас судалгааны үр дүнг нийтлүүлэхэд дэмжлэг үзүүлэх.	2023-2027 он	Судалгааны үр дүн, эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлэгдсэн эсэх.	Судалгаа, эрдэм шинжилгээний ажлын үр дүнтэй бусад орны судлаач эрдэмтэд танилцах, олон улсын судалгааны эх сурвалж болох нөхцөл боломж бүрдэнэ.



ТАВ. ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГААС СУДАЛГААНЫ ТАЛААР БАРИМТЛАХ ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилт 3. Судалгааны ажилд шинжлэх ухаан, технологи, инновацийн ололт дэвшлийг нэвтрүүлэх				
1	Судалгааны программыг хэрэглээнд нэвтрүүлэх	2023-2027 он	Судалгааны программуудыг ашиглаж хэвшсэн эсэх.	Судалгаа хийх арга зүй, судалгааны чанар сайжирсан байна.
2	Олон улсын академик эх сурвалж, судалгааны санг ашиглах боломжийг бүрдүүлэх	2023-2027 он	Олон улсын судалгааны сангуудад нэвтрэх эрхтэй болсон эсэх.	Судалгааны ажилд гадаад улсын эрдэмтэн судлаач нарын бүтээл, эх сурвалжийг ашиглах, хэрэглэх боломж бүрдсэн байна.
3	Прокурорын байгууллагын судалгааны цахим санг бий болгох	2024 он	Цахим санг үүсгэсэн эсэх	Судалгааны үр дүнг прокурор, ажилтнууд ашиглах нөхцөл бүрдсэн байна.
Зорилт 4. Судалгааны ажлын үр дүнг практик үйл ажиллагаанд нэвтрүүлэх, эргэлтэд оруулах				
1	Судалгааны ажлын үр дүнд үндэслэн гарын авлага, ном, товхимол эрхлэн гаргах.	2023-2027 он	Гарын авлага, ном, товхимол гарсан эсэх.	Судалгааны ажлын үр дүн нийтэд танилцуулагдсан байна.
2	Олон улсын болон үндэсний эрдэм шинжилгээний хурал, бусад арга хэмжээг зохион байгуулах.	2023-2027 он	Холбогдох арга хэмжээнүүд зохион байгуулагдсан эсэх.	Судалгааны үр дүнг хэлэлцүүлж, зохих үр дүнд хүрсэн байна.
3	Судалгааны ажлын үр дүнд үндэслэн хууль тогтоомж, Улсын ерөнхий прокурорын тушаалаар баталсан заавар, журам, аргачлалыг шинэчлэн боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах талаар холбогдох саналыг боловсруулж, эрх бүхий албан тушаалтанд тухай бүр уламжлах.	2023-2027 он	Холбогдох саналыг боловсруулж, эрх бүхий албан тушаалтанд уламжилсан эсэх.	Хууль тогтоомж, заавар, журмыг нэг мөр хэрэгжүүлэх нөхцөл, боломж бүрдсэн байна.



ТАВ. ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГААС СУДАЛГААНЫ ТАЛААР БАРИМТЛАХ ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилт 5. Эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудтай хамтран ажиллах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх				
1	Дотоодын болон бусад орны ижил чиг үүрэг бүхий байгууллагатай хамтран судалгаа хийх, зочин судлаачаар ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх.	2024-2027 он	Хамтарсан судалгаа хийх, зочин судлаач ажиллах нөхцөл бүрдсэн эсэх.	Судалгаа, эрдэм шинжилгээний ажлын чанар сайжирч, хамтын ажиллагаа өргөжсөн байна.
2	Прокурор, ажилтнуудад судалгааны арга зүй эзэмшүүлэх, мэргэшүүлэх, судалгааны чиглэлээр төсөл хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх.	2023-2027 он	Судалгааны арга зүйн сургалтуудыг үе шаттай зохион байгуулж, төсөл хөтөлбөр хэрэгжсэн эсэх.	Прокурор, ажилтнуудын судалгааны арга зүйн мэдлэг, ур чадвар сайжирч, судалгааны талаар баримтлах үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд зохих хувь нэмэр оруулсан байна.
3	Прокурор, ажилтнуудын боловсролын зэрэг, эрдмийн цолыг ахиулахад бодлогын дэмжлэг үзүүлэх.	2023-2027 он	Прокурор, ажилтнуудын судалгааны ажилд дэмжлэг үзүүлсэн эсэх.	Прокурор, ажилтнууд мэргэшиж, чадавхижсан байна.



ТАВ. ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГААС СУДАЛГААНЫ ТАЛААР БАРИМТЛАХ ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Прокурор, ажилтнуудын боловсролын зэрэг, эрдмийн цолыг ахиулахад бодлогын дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд:

- Прокурор, ажилтнуудыг байгууллагын зардлаар магистр, докторын сургалтад хамруулах ажлыг хэрэгжүүлэх үүднээс тавигдах шаардлагыг УЕПГ-ын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгээс боловсруулж, 2023 онд тус хөтөлбөрт 2 прокурорыг хамруулахаар шийдвэрлэсэн.
- Прокурор, ажилтнуудыг Шихихутуг их сургуулийн магистр, докторын хөтөлбөрт хөнгөлөлттэй нөхцлөөр сургахаар шийдвэрлэсэн.



Үр дүн, ач холбогдол

- “Прокурорын байгууллагын 2023-2026 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”-нд судалгааны чиглэлээр тусгагдсан зорилт, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх бодит нөхцөл бүрдэнэ.
- Судалгааны талаар авч хэрэгжүүлэх нэгдсэн бодлого, чиглэл, арга хэмжээ тодорхойлогдоно.
 - Судалгааны ажлын чанар, үр нөлөө нэмэгдэнэ;
 - Хүний нөөцийн чадавхи сайжрах;
 - Судалгааны ажилд шинжлэх ухаан, технологи, инновацийн ололт дэвшлийг нэвтрүүлэх;
 - Эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудтай хамтран ажиллаж, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх гм.



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА.